

ЧИНГИСИЙН ОНГОНЫ БУЛГАН ХУТГИЙН УЧИР

Н. Хурцбилт

/Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэн/

ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ УТГА: Чингисийн онгонд эртний Монголын маш олон тахилга мялаалгуудын зан үйл хадгалагдаж байдаг. Түүний нэг нь булган хутаг мялаах зан үйл болно. Чингисийн тайлгын дарамжид \дараалал\ “булган хутаг”, “хутаг ерөөнө”, “хутаг мялаана” гэж байдаг нь тэрхүү зан үйлийг зааж байгаа юм. Булган хутаг ба түүний бэлгэдлийн учрыг тайлан тодорхойлсон өгүүлэл зохиол одоохондоо хараахан гараагүй болохоор эл өгүүллийг туурвиж энэ зүгт анхаарал тавьж буй эрдэмтдэд лавлалт болгоё.

Нэг. Энгийн утга дээрхи булган хутаг

Булган бол булгын хөдлөх үндэс эсэ хөдөлсөн хэлбэр болно. Булга бол Монголын өндөрлөг төдийгүй дэлхийн өндөрлөг сэрүүн газар амьдардаг нэг зүйлийн амьтан. Түүний тухай “Амьтны зурагт толь”-д “мхчны баг, солонгын язгуур, булганы төрөл. Бие нь 0.49м урт, 0.1м өндөр, сүүл нь 0.17м урт. Толгой нь кижиг дүгэрэг, хошуу нь нарийн шовх, хамар нь нүцгэн, ам нь том, сахал нь урт, шүд нь 38 байдаг. Нүд нь жижиг, чих нь гурвалжин шовх, хүзүү, бие нь нарийн урт, сүүл нь дунд зэрэг байгаад сагсгар. Дөрвөн мөч нь уртавтар бөгөөд хурц хумстай, бие нь харавтар хүрэн байгаад шаравтар сортой байдаг. Өтөн ой дотор мэргэчин, шувуу, загас, зэрлэг жимс зэргээр хооллодог бөгөөд модонд авирахдаа сайн, 6-10сар хээл тээж, жилд нэг удаа 2 зулзага төрдөг. Хамгийн үнэтэй ангийн арьс болдог. Манай улсын баг Хянган даваа, Чанбайшан уул, Алтай уулаар тархана” [1] гэж тэмдэглэжээ. Энд гарах Чанбайшан уул бол одоогийн Гирин мужийн Солонгос үндэстний өөртөө засах Жөү Ду Буй Чанг Бай Шан уул болно. Чингисийн онгоны “Өтгийн их өчигт”, “Тэмүүжин Богд Чингис хааны их алтан төгөл” [2] тэргүүнд “Үнэгэн мөрөн нутагт, унасан цасан идэшт. Булган хэрмэн дээлт. Цагаан Солонгос улс” гэж гарч бйхаар үзвэл дээр үед Солонгос булганы арьс элбэг бөгөөд үнэтэй байжээ. Булга ба түүний арьсны тухай “Хорин нэгт тайлбар толь”-д “үнэд адилхан, өнгө бараан шар адилгүй, хөхмэй буй, үс зохистой болоод хэ”, “үстийн дотоод маш эрхэм нь буй”[3] гэж тайлбарласан бол “Монгол үгсийн язгуурын толь”-д “зөөлөн сайхан арьс үстэй, нэг зүйлийн амьтан: булган малгай: булган дээл: булган сүүл (өвс)[4] гэж тэмдэглэжээ. Түүнчлэн “Монгол хэлцийн далай”-д “булган сүүл (ургамал)” [5] гэж байхаар үзэл монголчууд булганы сүүлийн маягтай нэг зүйлийн ургамлыг тийнхүү нэрлэдэг байжээ. Энэ нь булан сүүлийг анхаарч сонирхож байсан ба өлзий мөрийн бэлгэдэл болгон дээдэлж байсан лугаа холбоотойнэрийдэл байх гэж үзлээ.

Хутаг бол өлзий хутгийн хутаг болно. Үүнийг Хар бухын балгаснаас илрүүлсэн үйсэн бичиг ХВМ82. 4V хуудсанд “Байдар саарьт алтан барим хөхт үнэгийг сүр сүнсэн өлзий хутгийг чинь гуйном хуруй гэж гардагаас тодорхой мэдэж болно. Хутаг гэдэг үгийг монголчууд нэр үгийн хувиар өргөнөөр хэрэглэж байжээ. Жишээлбэл: “Монголын нууц товчоо” (цаашид <нууц товчоо> гэнэ) –нд Хутугбэх, Шихихутуг зэрэг хүний нэр байх ба бурханы ном сударт “Өлзий хутаг цогцолсон нэрт их хөлгөн судар”, “Хутагт насан хийгээд бэлгэ билиг цаглашгүй хэмээгдэх их хөлгөн судар” гэх нэр байдаг бөгөөд монгол хэлээр орчуулсан буюу бичсэн бурханы ном сударт хутаг гэдэг үг нэлээд дээгүүр давталттай байдаг. Жишээ нь: Хар бухын балгаснаас илрүүлсэн. Жич хаад ноёдын цолд “Хутагт хаан”, “Хутагтай цэцэн”, одоогийн хүний нэрэнд “Өлзийхутаг”, “Баянхутаг”, “Буянхутаг” гэж байдаг нь энэ үг эртнээс эдүгээ болтол идэвхитэй хэрэглэгдсээр ирсэн уламжлал байна. Түүний утгын тухай “Монгол хэлний толь”-д[6] “хувь зохиол, буяны хувь” гэж, “Монгол үгсийн язгуурын толь”-д “хувь зохиол, хишиг буян, амь нас, эрэл хүсэл” [7] гэж тус тус тайлбарласан байна. Энэ үг их эрт байсан болохоор лам нар бас өөрийн гэсэн тайлбар хийдэг байжээ. Тухайлбал: “Буддын шашны соёлын тайлбар толь”-д “Бурханы шашны номын ёсоор бурхан, ном, хуврага тэргүүтний алдрын өмнө хойно зүүх хүндэтгэл”[8] болно гэжээ. Цахарт хутаг буян гэж холбоос хэрэглэх нь олон. Жишээ нь: Хурмаст тэнгэрт хүрч хотол сайныг хүргэ, хорвоод буцан ирж хутаг буяныг авчир. Ордост ялангуяа их эзэн хорооны шар дархадын дунд бэлгэ хутаг гэж хоршуулж хэлэх нь олон. Жишээ нь: Эзэн! Бэлгэ хутаг үгүй юм. Үүгээр үзвэл түүнд буян хишиг, өлзий бэлгэ гэсэн утга санаа агуулж байх ажээ. Энэ нь өлзий хутгийг Уйгар, Түрэгээр хутулуг гэдэгтэй нэлээд төстэй юм. Хутаг бол Түрэгийн аз хийморийг заасан худ гэх нэр үг дээр монгол хэлний үйл үгнээс нэр үг үүсгэх –г дагавар залгаж үүсгэсэн нэр үг болно. Иймэрхүү хэлбэртэй нэр үг монгол хэлэнд олон байдгаас нэг хоёр жишээ авбал: буд + г = будаг, бич + г = бичиг гэх мэт.

Хоёр. Чингисийн онгоны булган хутаг

Чингисийн онгоны булган хутгийн тухай тэмдэглэсэн зүйл тун ховор. Учир нь дээр үед нууц зүйл байж тэр болгон хүнд үзүүлдэггүй байсанд оршино. Гагцхүү эл хошууны алтан урагтан буюу тэдний төлөөлөгч тусгайлан хүрэлцэн ирж мөргөвөл сая булган хутгийн адис хүртдэг байжээ. Үүний тухай өнгөрсөн зууны эхээр түүнд мөргөх гэж аавыгаа дагаж их эзэн хороонд очсон Балжинням (1904-1989) [9] бидэнд: “Булган хутаг гэж юу байдаг юм бол гэж их гайхаж байсан чинь дархадын яамтан бэр эзний мөнгөн давсагаас \мөнгөн хайрцагийн хүндэтгэсэн утга\ нэг булганы сүүл гаргаж ирээд адис өгчээ.” [10] гэх сонирхолтой дурсамж үлдээсэн байна. Энэ нь ортой юм гэдгийг бид “Авгын зан ааль”-д “хүмүүсийн хэлэлцэхээр түүний дотор Чингисийн сүлдийн хөрөг байснаас гадна есөн булганы арьс байв гэдэг. Бас зарим нь есөн булганы сүүл ч гэдэг” [11], “Сүлд нь хүрэн зандан модон хайрцагт агуулсан нэг суусар булганы сүүл байдаг гэнэ. Тэр сүүл нь Чингис буюу бөх Бэлгүтэйн малгайн ар шилэнд хадаж байсан бүч нь юм гэдэг домогтой. <Чингисийн сүлд> нь суусар булганы сүүл байсныг нүдээрээ үзлээ гэж авга хамба Галсанрахваа ярьж байсан гэдэг бөгөөд Бат-Очир гуай 1950 онд дундад холбоот хошууны дэд дарга байхдаа <Чингисийн сүлд>-ийг судласнаа <хэрмийн сүүл шиг саарал сүүл байсан> гэж эргэцүүлээ гэж түүх судлаач Г. Жамьян гуайд мэдээлжээ” [12] гэснээс мэдэж болно. Үүнд нэг, хоёр хөндлөнгийн баримт гаргавал: “Хангин шүтээн”-ийг “гаднаас нь харахад булга, халиу, үнэг, чоно гэх мэтийн ангийн амьтны элдэв арьс үс ба сувд шүр, оюу тана хадсан, гууль хүрлээр хийсэн хонх, сум өлгөсөн элдэв өнгийн хадаг зангилгаагаар бүрсэн” эд байдаг [13]. Уул нь Хавт Хасарын “Сүлдийн ордон”-д хадаг яндар гэдэг юм үгүй харин булга, халиу, үнэг зэрэг нарийн үстэй арьс зүүж байжээ.

Чингисийн онгоны булган хутаг гэдэг нь булганы сүүл байсан болов үү гэж бодно. Чингисийн онгоны булган хутгийн тухай “Алтан ордны тайлга”-д “Чингисийн чандарын хайрцагны зүүн баруун хоёр талд булганы арьс, таван өнгийн дурдан пансыг сагсайлган боож тавьсан <хутаг> гэгч юм байдаг. Энэхүү хутагийг авч цомцогийн нуруунаас дүүжлэн мялаадаг. Энэ нь хөдөө айлын монгол гэрийн тооно ба байшингийнхаан нуруун голоос зүүсэн буян хишиг хурах өлзий хутгийн яндар ба унгас хялгасан хутагтай ойролцоо шиг болой” [14]. “Монгол тахилга”-д Чингисийн гэгээн дүрийг залсан хайрцагны зүүн баруун хоёр талд байх булган хутагийг авч цомцогийн нуруунаас дүүжлэнэ. Энэ нь хөдөө айлын монгол гэрийн тооно ба байшингийн гол нуруунаас зүүсэн буян хишиг хурах өлзий хутгийн яндар ба унгас хялгасан хутагтай ойролцоо юм болно. Ингээд цомцогийн нуруунаас зүүсэн булган хутгаан их манлай, цэрви хоёр айраг тос, өтгийн дээжээр мялаахад хөхчин: <хутаг мялаах ерөөл> хэлнэ” [15]. “Чингис хааны тахилгын соёл”-д “Эзэн Чингис болон Бөртэ хатны хайрцагийн хоёр талд булганы арьс, таван өнгийн дурдан зэргээр сагсайлган боож тавьсан <хутаг> гэгч байдаг. Үүнийгээ авч цомцогийн нуруунаас зүүн мялаадаг. Энэ нь хөдөө айлын монгол гэр буюу байшингийн ноён нурууны голд өлгөсөн

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

буян хишиг хурах өлзий хутгийн яндар ба унгас хялгасан хутагтай ойролцоо шиг байдаг”[16] гэж үндсэндээ адилавтор тэмдэглэсэн байж билээ. Үүнд бас нэг баримт гаргавал: Хангин “Гол шүтээний баруун зүүн хоёр талаар хадсан ангийн элдэв амьтны арьс үсний дотор талаар хөх эрээн хоргой, улаан эрээн хоргой, шар эрээн хоргойгоор хошуулдан бүч гаргаж, түүний дээр бяцхан хонх, хүрэл сумнуудыг тогтоосон байдаг бөгөөд бас оюу шүр, сувдыг ч энд тэнд нь хадсан байдаг аж”[17]. Зарим тэмдэглэлд булган хутгийг “булганы арьс” гэж тэмдэглэж байх нь яг өөрийн нүдээр олж үзсэнгүй дам сонссоноо бичсэнээс болжээ. Булган хутаг бол гэрийн өрхөөс зүүж мялаах зүйл байсан болохоор гэрэл гэгээг халхлахгүйн дээр гал тогооноос зайтай байх ёстой. Тиймээс тэр нь төө хир урт булган сүүл л байж болох юм.

Гурав. Булган хутгийн бэлгэдэл санаа

“Монголын нууц товчоо”-ны 105 дугаар зүйлд “Тэр хөхдөг \онгиороо сагсуу\ Тогтохийн өрх дээр ину орж, эрхин эхэд ину эмбүри дайрч, эм хөвгүүн ину эцэстэлээ агуулуйяа, хутаг эхдээ ину хугараа дайрч, хотолоо улсыг ину хоосон болтол агуулуйяа”[18] гэх тэмдэглэл байдаг. Энэхүү тэмдэглэлийг Д. Цэрэнсодном “Өнөөх хулчгар Тогтохын өрхөн дээр нь бууж, эрхин үүдийг нь өм дайрч, эмс охидыг нь эцэслэн дуусгая, хутаг үүдийг нь хуга дайрч хотол улсыг нь хоосон болтол нь талья”[19] гэж орчуулж буулгасан байна. Олонд тархаснаар эхдээгийн язгуур бол эх \эцэг эхийг эх\ буюу эх \голын эх\ болно. Эх буюу эх нь ямар нэгэн юмны үүслийн цэг болохоор түүнийг монгол гэрийн тооно, унь, ханын үүслийн цэг гэж ойлгож болно. Энд гарах нэг дүгээр эхэдийг хятад хажуугийн орчуулгад (zhang fang gu zi) гэж, хоёр дугаар эх-ийг (men kuang) гэжээ. Энэ нь нийлээд гэрийн үүд өрхийг заасан байж болох талтай. Учир нь газар урцын үед өрх нь газар урцын ноён нуруу болох мөртлөө үүд өрх байсанд оршино. Эрхинийг (jin yao de) гэж, хутгийг (fu shen de) гэжээ. Энэ нь нийлээд эрхэм хутаг болж байна. Үүгээр үзвэл аль эрт 12 дугаар зууны үед Монголчуудын дотор буян хишгийн ухамсар хүчтэй дэлгэрч, гэрийн үүд өрхөнд айл гэрийн буян хишгийг агуулсан хутгийг байнга өлгөдөг зан үйл оршиж байжээ. Энэ нь Сөнөдийн “Үүдэн тэнгэр”-ийг эрхгүй санагдуулдаг. Түүний тухай “Сөнөдийн язгуур шүтлэг”-т “Үүдэн тэнгэр” одоо тэрхүү зан үйл нь монгол гэрийн тоононоос татсан чагтагны угт хадаг зангидаж зарсан \төхөөрсөн\ мал тэмээний унгас хялгасыг өлгөж, малын буян хишгийг хадгалах хэлбэр болж уламжлагдаж байх ажээ. Яг иймээс Ордосын “Шинэ гэр мялаах ерөөл”-д: “Бат цагаан бараа нь \бадам лянхуан шинжтэй\, бага их олондоо \баян өргөн хишигтэй\, алтан хорлын голтой \амьд эрдэнийн сийлбэртэй\, зандан модон цагирагтай \чандмана эрдэнийн шинжтэй\, нарны элчит гэрлээс \насан хутгийг тогтоосон\, сарны ивээлт туяанаас \сайны хишгийг хураасан\, өндөр их тоонот”[18] гэж ерөөсөн бол өөр нэгэн “гэр мялаах ерөөлд” “Эрдэнийн цагаан хулгийн дэлээр томож хийсэн, эгч дүү нарын гарын тамираар нийтгэж бүтээсэн, алтан зоос ариун хэвийн чимэгтэй, аливаа буян хишиг хурсан чагтагыг чинь мялааа”[19] гэжээ.

“Ордосын аман аялгууны үгсийн хураангуй”-д булган хутаг гэдэг үгийг анх удаа толилж, “Чингисийн найман цагаан гэр дэх буян хишиг хурахыг зөгнөсөн бэлгэдлийн эд. Булганы арьсыг таван өнгийн хадаг яндараар ороосон эд”[20] гэж тайлбарласан байдаг. Эртний монголчууд хутаг гэдэг нүдэнд үл үзэгдэх, гарт үл баригдах тэр юм дулаан зөөлөн зүйлд оршиж болно гэж ойлгож байсан тул хутгийг булганы сүүлд оршуулж урт хугацаагаар хадгалж болдог гэж ухаарч байжээ. Яг иймээс хүмүүсийн халуун дулаан уул ус, нутаг орноон булгатай зүйрлэж булган уул, булган тал гэж ярих заншилтай байдаг. Иймээс ар монголд “Их, бага богд булган хангай” гэж дуулсан бол өвөр монголд “Булган тохой нутаг” гэж уянгалуулсан байдаг. Энэ нь дээр үеийн хүн булганы арьсыг туйлаар эрхэмлэн нандигнаж

байсан лугаа холбоотой дуу байж болох юм. Сүүлийн үеийн шинэхэн судалгааны үр бүтээлийг үндэслэвэл: Газрын дундад тэнгисийн хавьд одоогоос бараг түм хоёр мянган жилийн тэртээ амьдарч байсан дунд чулуун зэвсгийн үеийн ахимаг настай удганы онгоноос нэг булганы толгойн ясыг илрүүлсэн байна [21]. Энэ нь эртний нийгэмд нийгмийн байр сууриар өндөр хүн болгоны гаралтыг урьдаар эдэлж хэрэглэх эрхтэй байсныг харуулж байна. “Нууц товчоо”-ны 9 дүгээр зүйлд “Булган хэрмэн гөрөөтэй газар”[22], 96 дугаар зүйлд “Цодон эхийн шүтээл хэмээн хар булган дах авчирч бүлгөө”[23], 97 дугаар зүйлд “Тэмүүжинг төрөхөд булган нэхий өглөө би”[24], 114 дүгээр зүйлд “усны булган дээлт таван наст хүчит нэрт”[25] гэж тус тус гарч байх ба Чингис хааны “Алтан бичиг” дэх “Мялаагуутын ерөөл”-д “Буурал морь хээр Шунхлай улаатай билээ. Булган арьсан хэдрэгтэй билээ. Буянт сайн төрийн хаан хатан хамаг улс энхсэн жарган заяан атугай”[26] гэж байхаар үзвэл, Монголын хаан хатад аль эртнээс булганы арьсыг эрхэмлэж хувцас засалд хэрэглэж байжээ. Тиймээс хаан хатадыг гүн оршуулахдаа зүүж өмсөхөд хээнцэр гоё гэж, газар доорхи чанад ертөнц хүйтэн жинтэй гэж булган малгай зүүлгэж, булган дах өмсүүлж оршуулдаг байсан юм.

Тэр үеийн хүн болгон арьсыг эрхэмлэн эдлэхээр барахгүй төрийн бэлгэд, улсын сааль өгдөг байсныг “Нууц товчоо” дахь “Эрт өдөр эцэг лүгээ мину анд хэмээлдүгсэн ажгуу. Эцэг хүү мэтү буюу жа хэмээжү, гэргий буулгаж өмсгөл чамд авчирав хэмээн булган дах өгөв” [27] гэх тэмдэглэлээс мэдэж болно. “Дотоод улсын түүхэн хүрээлэнгийн данс”-ын тэнгэрийн сэцэний наймдугаар он (1634)-ы цагаан сарын шинийн хоёрны тэмдэглэлд: “Галзуу Сатар зургаан морь, гучин булганы арьсыг шинэлэх бэлэгт өргөв” [28] гэж тэмдэглэж байхыг үзвэл иймэрхүү хүндэтгэлийн заншил Айшин гүрэн цаашилбал Чин улсын үе хүртэл уламжлагдаж байжээ. Монголчууд булганы арьсыг ийнхүү эрхэмлэн дээдэлж байсан тул булган сүүлээр сайн сайхан үйл хэргийн эхлэлт ба өлзий буянтай учир явдалыг бэлгэддэг болжээ. Эдүгээ ар монголын аман ярианд “Булган сүүлтэй хүү”, “булган сүүлтэй баатар”, “булган сүүлтэй тамирчин”, “тэр миний булган сүүл байсан” гэж сайн үйл хэргийн дагуулагч болсон хүнийг булган сүүлээр зүйрлэн хэлдэг нь тэрхүү бэлгэдэл санааны үг хэл дээрх тусгал байж болох юм. Чингис хаан бол монголын зууныг эхлүүлсэн ёстой булган сүүлтэй агуу их морьт баатар болох юм. Яг иймээс Чингисийн онгонд хадгалан тахидаг булган хутгийг “Өгөөдэй хан хөвгүүний түшээн болгосон, Харилмай /уруудсан/ Монголдоон тулган болсон” гэж ерөөдөг ажээ. Энэ нь алтан урагтан ба тэдний ноёлол доорх өргөн олон монголчууд хэд хэдэн зууны турш өөрийн хувь заяагаан эзэмдэж ирсэн нь булган сүүлтэй богд эзний минь ач тус гэж санал нэгтэй мэдрэн зөвшөөрдөг байсныг харуулж байна.

Бөө мөргөлтөн хутгийг сайхан хадгалж, сайтар хямгадахгүй бол зайлж холдох аюултай гэж тайлбарладаг болохоор, Чингис хааны хутгийг жил жил тахин хурайлж, булганы сүүлд оршуулж хадгалдаг байна. Олонхи монгол газарт саяхан болтол уламжлагдаж байсан дээдсийн буян хишгийг хурайлж даллагын суулгад хадгалах зан үйл бол тэрхүү зан үйлийн ардын дундхи ул суурь байж

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

болно. Чингис хааны алтан ордны “Мялаагуудын өчиг”-д “Уртад явах буян хишиг, өлзий хутаг их жаргаланг хаан хатан хамаг улсад эгэл хутаг энх эсэнийн заяа нь атугай” [29] гэж гардаг. Энд гарах “эгэл хутаг” бол эгэл жаахан буян хишиг, “энх эсэн” бол өнө үүрдийн эрүүл мэнд болно. Үүгээр үзвэл, эртний монголчууд Чингис хаан хийгээд түүний хатны булган хутагт дахин дахин мөргөж, өөрийн хувь заяагаан зузаатгаж амь насаан уртасгах наманчлал хийдэг байжээ. Гэхдээ ажил хөдөлмөрт тэргүүлсэн хүнд Чингис хааны соёрхосон буян хишиг илүү тогтож, эрүүл мэнд удаан байх тухай “Мялаагуудын ерөөл”-д “Хөх хонь алахуй дор хүчит сайхан тайж нар тэргүүлэм билээ.”[30], “Түрхүйдээн дөхүүгэнэм билээ, төр тань сайхан тайж нар тэргүүлэм билээ” гэж бичсэн бөгөөд зарим баячууд булган хутагт мөргөөд их баян болсон тухай “Баху баян гунжин ингээ гучин түм болгоном билээ, дүнжин ингээ дөчин түм болгоном билээ, эвэр эвэр хэм идээн дүүргэм, шивэр шивэр хэм суулга дүүргэм”[31] гэж жишээ авчээ.

Алдарт сурвалжлагч Балжинням гуай “Мянган оны донж нэгэн Чингис хаан”-ыг бичихэд Чингис хааны бүтээсэн дэлхийн хамгуудаас юу юу байна гэж надаас асуухад би: Тухайн үеийн дэлхий дээрх хамгийн олон мал хөрөнгөтэй хүн” гэх нэг зурвас дурдсан юм. Сүүлээр харвал тэр нэг зурвасыг санаандаа авсан шиг байж билээ. Үнэндээ тийм. Түүний мал хөрөнгийг одоогийн үнээр нугалан бодсон ч дэлхий дээр хэн яаж тэнцэх билээ. Иймээс Чингис хааны хэм садгүй \хэмжээгүй\ буян хишгийг хадгалан буй булган хутагаас өчүүхэн төдий адис хүртэх нь түүний үр хойчис ба өргөн олон монголчуудын баяжиж хөлжих хүсэл эрмэлзлэлийнх нь тусгал болж эдүгээ хүртэл уламжлагдаж байх ажээ. Өнөөдөр зах зээлд орж хөрөнгө мөнгө чухал болоход Чингис хааны булган хутагт мөргөх зан үйл нь хөрөнгөгүй хүн хөрөнгөтэй болох, хөрөнгөтэй хүн их хөрөнгөтэй болох хүсэл мөрөөдлөөн далдын хүчинд даатган наманчлах зан үйл болсон байна. Соёл хүн зүйн холбогдол бүхий онолыг үндэслэвэл: хүмүүс хүсэл бодлоо ямар нэгэн далдын хүчинд найдаж биедээн өмөг түшиг авч хийе биелүүлье гэсэн ажилдаа бүх сэтгэл, бүх зоригороон зүтгэж, итгэл дүүрэн ажиллах нь амжилт олохын баталгаа болдог гэдэг. Энэ бол одоо болтол ардын дунд уламжлалт тахилга мялаагууд оршиж байгаагийн гүн далд үндэс суурь болно. Ер нь зорилгоон тогтоосоны дараа ямар нэгэн далдын хүчинд залбирч, хатуужилтай, цуцалтгүй, удаан даамгай, ухаан санбаатай, шинжлэх ухаанчаар ажиллаж хөдөлмөрлөх бол монголчуудын ажил үйлс бүтэхийн чухам оньс мөн билээ. Яг иймээс Богд Чингис хаан: “өндөр уулыг бэрх хэмээн бүү цөх, хөтөлийг зоривоос гар юу, өргөн далайг гүн хэмээн бүү ай, оломыг зоривоос гатал юу” гэж сургасан нь цаанаа маш гүн утга учиртай байсан ажээ. Хураавал: Чингисийн онгоны булган хутаг бол нүүдэлчдийн булганы арьсыг дээдлэх, амьдралын зан үйл дээр суурилсан эртний монголчуудын хутаг хадгалах, ерөөх, мялаах, тахиx зан үйлтэй холбоотой тун их бэлгэдлийн чанартай булган сүүл болно. Чингис хааны үлдээсэн буян хишгийг булган сүүл, булган арьс, цаашилбал булган дахт хурайлан оршуулж жил жил тахиж мялаах зан үйл бол судлууштай мөртлөө хадгалууштай зан үйл

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

болох юм. Ямар ч байсан Чингис хаан бол булган сүүлтэй хүн юм. Тэр сүүл нь монголчуудын дээдсийн буян хишгээр энх тайван, өөд өөдөн өсөн дэвжих, баян элбэг амьдрах гэсэн оюун санааных нь өмөг түшиг болж он удаан уламжлагдах нь дамжиггүй.

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

Зүүлт

- [1] Жигмэддорж, Урт, Нуннайжав: “Амьтны зурагт толь”, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 1986 он, 1555 дугаар тал
- [2] Эдүхишигийн “Чингисийн алтан бичгийн хуулбар” Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн номын сангийн хадгаламж, болд бийрийн бичмэл, 40 дүгээр тал
- [3] “Хорин нэгт тайлбар толь” Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1979 он. 265 дугаар тал
- [4], [7] Цэцэнцогтын найруулсан “Монгол үгсийн язгуурын толь”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1988 он. 790, 1133 дугаар тал
- [5] Бүрэнтөгсийн найруулсан “Монгол хэлцийн далай”, Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо, 2001 он, 549 дугаар тал
- [6] Ц. Норжин Ман Мөрөн нарын найруулсан “Монгол хэлний толь”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1999 он. 1477 дугаар тал
- [8] Ш. Чоймоонарын найруулсан “Буддын шашны соёлын тайлбар толь”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2003 он. 762 дугаар тал
- [9] Балжинням нь Их зуу аймгийн засаг хошууны тамгын газрын жинхэнэ бичээч, арван хийдийн дэмчийн дарга байжээ.
- [10] 1985 оны 5 сарын 3 өдөр Балжиннямыг сурвалжилсан хувийн тэмдэглэлээс.
- [11], [12] Урианхан, Ганганцэцэг, Билгүнүдэй, Н.Бөх-Хад эмхэтгэн найруулсан “Авгын зан ааль”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2003 он. 361, 362 дугаар тал
- [13] Сайнжаргал, Шаралдай цуглуулан эмхтгэсэн “Алтан ордны тайлга”, Үндэсний хэвлэлийн хороо, 1983 он. 58 дугаар тал
- [14] Сайнжаргалын найруулсан “Монгол тахилга”, Үндэсний хэвлэлийн хороо, 2001 он. 122 дугаар тал
- [15] Шаралдай, Нацаг нарын эмхэтгэсэн “Чингис хааны тахилгын соёл”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2008 он. 82 дугаар тал
- [16], [27] Баярын галиглаж буулгасан “Монголын нууц товчоо”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1981 он. 278, 217-218 дугаар тал
- [17] Далантайн Цэрэнсодномын “Монголын нууц товчоо”-ны орчуулга тайлбар, Үндэсний хэвлэлийн хороо, 1993 он. 77 дугаар тал
- [18] Чоглойнамжилын цуглуулан эмхэтгэсэн “Ордос ардын яруу найраг”, Үндэсний хэвлэлийн хороо, 1993 он. 67 дугаар тал
- [19] О. Цахилал: “Монгол гэрийн ерөөлийн соёл судлал”, Өвөр Монголын Их Сургуулийн хэвлэлийн хороо, 2007 он. 262-263 дугаар тал

II МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАТ ҮЕИЙН АСУУДАЛ

[20] Сономын найруулсан “Ордос аман аялгууны үгсийн хураангуй”, Үндэсний хэвлэлийн хороо, 1990 он. 151 дугаар тал

[21] Уртнасангийн орчуулсан “Дэлхий дээрх хамгийн эртний удганы онгон”, “Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан”, 2009 оны 6 дугаар хугацаа

[22], [23], [24], [25] Ш. Гаадамбын төсөөлөн нягтлаж сэргээсэн “Монголын нууц товчоо”, Улаанбаатар, 1990 он, 8, 38, 39, 53 дугаар тал

[26],[29], [30],[31] Шинээр ариутган тунгаасан “Чингис хааны алтан бичиг”, Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, 2000 он, 63, 73, 66, 66 дугаар тал

[28] “Чин чу нэй гуо ши юань ман вен дан ан и биан”, “шан це”, ди 57 еэ